



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө залруулж бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороонд байрлах нийт 8,575,504,800.93 (найман тэрбум таван зуун далан таван сая таван зуун дөрвөн мянга найман зуун төгрөг ерэн гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй иж бүрэн дэд өртөөний барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу залруулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгөд хамаарах газрын эзэмших эрхийг хууль тогтоомжийн дагуу компанийн нэр дээр баталгаажуулан авах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны "Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай" 533 дугаар тогтоолын хавсралтын 45, 46, 47 дугаар мөрөнд тусгагдсан нийт 4,330,130,289.60 (дөрвөн тэрбум гурван зуун гучин сая нэг зуун гучин мянга хоёр зуун наян есөн төгрөг жаран мөнгө) төгрөгийн үнэ бүхий 3 багц үндсэн хөрөнгийг бүртгэх заалтыг тус тус хүчингүйд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000019

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 2 дугаар сарын 11-ны өдрийн
34 дугаар тогтоолын хавсралт

**"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨ ЗАЛРУУЛЖ БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Балансын үнэ	Улсын комисст хүлээлгэн өгсөн огноо, дугаар
	(төгрөгөөр)		
1	110кВ-ын габриттай ЦДАШ, кабель	2,084,267,588.00	2012.12.19, 02/96/2012
2	10кВ-ын хувиарлах байгууламж /РП/ барилга байгууламж	83,316,961.50	2012.12.19, 02/96/2012
3	10кВ-ын хувиарлах байгууламж /РП/ тоног төхөөрөмж	1,916,791,986.00	2012.12.19, 02/96/2012
4	10кВ-ын хувиарлах байгууламж /РП/ барилга байгууламж	83,316,961.50	2019.07.19, 2019/252
5	10кВ-ын хувиарлах байгууламж /РП/ тоног төхөөрөмж	1,916,791,986.00	2019.07.19, 2019/252
6	2*1000кВ-ын дэд станц барилга	136,185,667.00	2016.01.08, 2016/19
7	2*1000кВ-ын дэд станц тоног төхөөрөмж	240,475,539.60	2016.01.08, 2016/19
8	2*1000кВ-ын дэд станц барилга	136,185,667.00	2019.07.19, 2019/251
9	2*1000кВ-ын дэд станц тоног төхөөрөмж	240,475,539.67	2019.07.19, 2019/251
10	2*1000кВа КТП тоног төхөөрөмж	240,475,539.67	2016.01.08, 2016/19
11	2х630кВ-ын дэд станц барилга байгууламж	136,185,667.00	2013.03.04, 134/2013
12	2х630кВ-ын дэд станц тоног төхөөрөмж	241,633,046.00	2013.03.04, 134/2013
13	10кВ-ын гадна цахилгаан кабель шугамын	927,024,859.00	2013.03.04, 134/2013
14	Үерийн хамгаалалтын далан суваг	192,377,793.00	-
Нийт дүн		8,575,504,800.93	-
		(найман тэрбум таван зуун далан таван сая таван зуун дөрвөн мянга найман зуун төгрөг ерэн гурван мөнгө)	